

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСЛИЙН ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТЫГ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ХОЛБОГДОХ ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН ЛАВЛАГАА**

2018.06.25-ны өдрийн хувилбар

**Тайлбар:** Монгол Улсын Үндсэн хууль нь 267 заалттай, Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт төсөл нь 54 заалттай байгаа нь Үндсэн хуулийн нийт заалтын 20.2 хувийг эзэлж байна.

№	ҮНДСЭН ХУУЛИЙН ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТ /1992 он/	ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСЛИЙН ЗҮЙЛ, ХЭСЭГ, ЗААЛТ /2018 он/
1.		<p>Арван ес<sup>1</sup>дүгээр зүйл</p> <p>1. Нам иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлж, үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулна.</p> <p>2. Нам Үндсэн хууль зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарсан, эсхүл бусад хуулийг зөрчсөн бол Улсын дээд шүүх хуульд заасан үндэслэлээр намыг тараах хүртэл хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>3. Намын үйл ажиллагаа, санхүүжилтийн үндсэн зарчим, журам, ил тод байдал, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх болзлыг хуулиар тогтооно.”</p>
2.	<p><b>Хорин нэгдүгээр зүйл</b></p> <p>3. Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.</p>	<p><b>Хорин нэгдүгээр зүйл</b></p> <p>3. Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын <u>гучин нас</u> хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.</p>
3.	<p><b>Хорин нэгдүгээр зүйл</b></p>	<p><b>Хорин нэгдүгээр зүйл</b></p> <p><u>“4. Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо, журмыг хуулиар тогтооно.</u></p>

	<p>5. Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.</p>	<p><u>Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.</u></p>
<p>4.</p>	<p><b>Хорин хоёрдугаар зүйл</b></p> <p>2. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ эдэлнэ.</p> <p>Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол өөрөө тарах буюу эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргана.</p>	<p><b>Хорин хоёрдугаар зүйл</b></p> <p><u>“2. Дараахь тохиолдолд Улсын Их Хурал бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө тарна:</u></p> <p><u>1/ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны санал хураалтаар Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн;</u></p> <p><u>2/ Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаан эхэлснээс хойш дөчин тав хоногийн дотор, Ерөнхий сайдын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсноос хойш хорин нэг хоногийн дотор Ерөнхий сайдыг томилох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй.”</u></p> <p>3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр Улсын Их Хурлыг тараах шийдвэрийг Ерөнхийлөгч гаргана. Ийнхүү шийдвэр гаргаснаас хойш арав хоногийн дотор Улсын Их Хурал сонгуулийг товлон зарлах бөгөөд сонгуулийг 60 хоногийн дотор явуулна.</p> <p>4. Улсын Их Хурлын шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.</p>
<p>5.</p>	<p><b>Хорин тавдугаар зүйл. 1 дэх хэсэг</b></p> <p>6/ Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан</p>	<p><b>Хорин тавдугаар зүйл. 1 дэх хэсэг</b></p> <p>6/ Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, <u>Ерөнхий сайд</u>, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг</p>

	тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах;	бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах;
6.	<p><b>Хорин тавдугаар зүйл. 1 дэх хэсэг</b></p> <p>7/ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах;</p>	<p><b>Хорин тавдугаар зүйл. 1 дэх хэсэг</b></p> <p>7/ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах , <b>Улсын Их Хурал тухайн жилийн улсын төсвийг хэлэлцэн батлах явцдаа Засгийн газрын зөвшөөрөлгүйгээр зардлын шинэ төрөл үүсгэх, зарлага нэмэгдүүлэхийг хориглоно</b></p>
7.	<p><b>Хорин долдугаар зүйл</b></p> <p>2. Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна.</p>	<p><b>Хорин долдугаар зүйл</b></p> <p>2. Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас <del>дөөшгүй</del> <b><u>далан таваас доошгүй</u></b> ажлын өдөр чуулна.</p>
8.	<p><b>Хорин долдугаар зүйл</b></p> <p>6. Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ.</p>	<p><b>Хорин долдугаар зүйл</b></p> <p><b><u>“6. Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.</u></b></p> <p><b><u>Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар хуулийг батална.</u></b></p> <p><b><u>Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ.”</u></b></p>

9.		<p>Хорин долдугаар зүйл</p> <p>7. Улсын Их Хурлын гишүүн чуулганы болон Байнгын хорооны хуралдаанд биеэр оролцож, өөрийн итгэл үнэмшлээр санал өгнө.</p>
10.		<p>Хорин наймдугаар зүйл</p> <p>“3. Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь, эсхүл Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийн хүрээний тодорхой асуудлаар хянан шалгах түр хороог байгуулах тухай саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал дахь олонхи, цөөнхийн төлөөллийг оролцуулан байгуулж болно.</p> <p>4. Хянан шалгах түр хороо нь холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн, хараат бус шинжээч томилох, гэрч дуудах, тайлбар, мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах эрхтэй. Тус хорооны дүгнэлт шүүх, эрх бүхий бусад байгууллагад үүрэг хүлээлгэхгүй.</p> <p>5. Хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа асуудлаар хянан шалгах түр хороо байгуулахгүй.</p> <p>6. Хянан шалгах түр хороо байгуулах, ажиллах журмыг хуулиар тогтооно.”</p>
11.	<p><b>Хорин есдүгээр зүйл</b></p> <p>1. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.</p>	<p>Хорин есдүгээр зүйл</p> <p>1. Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь <u>Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол албан үүрэгт нь</u> үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.</p>

12.		<p>Хорин есдүгээр зүйл</p> <p>4. Улсын Их Хурлын гишүүн Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа нь түүнийг гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно.</p>
13.	<p><b>Гучин есдүгээр зүйл.</b></p> <p>1. Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.</p>	<p>Гучин есдүгээр зүйл</p> <p>1. Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.</p> <p>Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдийн гуравны нэгээс илүүгүй нь Улсын Их Хурлын гишүүн байж болно.</p>
14.	<p><b>Гучин есдүгээр зүйл</b></p> <p>3. Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж томилно.</p>	<p>Гучин есдүгээр зүйл</p> <p><b><u>3. Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнийг томилсон, чөлөөлсөн, огцруулсан шийдвэрийг Улсын Их Хуралд танилцуулж, Ерөнхийлөгчид хүргүүлснээс хойш 72 цагийн дотор Ерөнхийлөгч батламжилна.</u></b></p>

<p>15.</p>	<p><b>Дөчин гуравдугаар зүйл.</b></p> <p>1. Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл хугацаа дуусахаас өмнө огцрох тухайгаа Ерөнхий сайд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.</p> <p>2. Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүдийн тэн хагас нь нэгэн зэрэг огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.</p> <p>3. Улсын Их Хурал Засгийн газрыг огцруулах тухай өөрөө санаачилсан болон Ерөнхийлөгчийн санал, Ерөнхий сайдын мэдэгдлийг хүлээн авснаас хойш арван тав хоногийн дотор Засгийн газрыг огцруулах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ.</p> <p>4. Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Засгийн газрыг огцруулах тухай саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.</p>	<p><b>Дөчин гуравдугаар зүйл.</b></p> <p><u>1. Улсын Их Хурал дахь олонхи нь Ерөнхий сайдыг огцруулж, шинэ Ерөнхий сайдыг томилох тухай саналыг хамтад нь албан ёсоор тавибал Улсын Их Хурал гурав хоногийн дотор хэлэлцэнэ. Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар уг асуудлыг дэмжсэн бол шинэ Ерөнхий сайдыг томилсон, өмнөх Ерөнхий сайдыг огцруулсан тухай Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцно.</u></p> <p><u>2. Улсын Их Хурал дахь цөөнхийг төлөөлж байгаа гишүүдийн санаачилгаар Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах тухай саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал арван тав хоногийн дотор хэлэлцэж, нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ.</u></p> <p><u>3. Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.”</u></p>
<p>16.</p>	<p><b>Дөчин дөрөвдүгээр зүйл.</b></p> <p>Өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсч Засгийн газар тогтоолын төсөл оруулбал Улсын Их Хурал уул асуудлыг дөчин гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмаар шийдвэрлэнэ.</p>	<p><b>Дөчин дөрөвдүгээр зүйл.</b></p> <p><u>1. Ерөнхий сайд өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсч тогтоолын төсөл оруулбал Улсын Их Хурал арван тав хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэнэ.</u></p> <p><u>2. Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тухай тогтоолыг Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар батлаагүй бол Ерөнхий сайдыг огцруулах тухай тогтоол батлагдсанд тооцно.”</u></p>
<p>17.</p>		<p><b>Дөчин зургадугаар зүйл</b></p>

		<p>4. Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг улс төрийн шалтгаанаар ялгаварлан гадуурхах, сонгуулийн үр дүнгээр болон хуульд зааснаас бусад үндэслэлээр төрийн албанаас халах, чөлөөлөхийг хориглоно. Төрийн жинхэнэ алба нь мэргэшсэн, тогтвортой, эгэх хариуцлагатай байх, шатлан дэвших зарчимд үндэслэх бөгөөд түүний хэрэгжилтэд төрийн албаны төв байгууллага хяналт тавина.</p>
18.	<p><b>Дөчин наймдугаар зүйл.</b></p> <p>1. Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.</p>	<p><b>Дөчин наймдугаар зүйл</b></p> <p>1. Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум <b><u>нийслэл, хотын шүүх, сум, хот (орон нутгийн харьяалалтай)</u></b>” буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.</p>
19.		<p><b>Дөчин есдүгээр зүйл</b></p> <p>6. Шүүхийн ерөнхий зөвлөлийг дараахь журмаар байгуулна:</p> <p>1/ Шүүхийн ерөнхий зөвлөл арван нэгэн гишүүнээс бүрдэнэ. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэгэн бүрэн эрхийн хугацаанд ажиллана;</p> <p>2/ Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн гурвыг Улсын Их Хурал, хоёрыг Ерөнхийлөгч тус тус томилох бөгөөд тэдгээр нь хуульчийн мэргэжлээр арваас доошгүй жил ажилласан, хууль зүйн өндөр мэргэшилтэй байна;</p>

		<p>3/ Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн нэгийг хяналтын шатны шүүхийн шүүгчдээс, хоёрыг давж заалдах шатны шүүхийн шүүгчдээс, гурвыг анхан шатны шүүхийн шүүгчдээс сонгоно;</p> <p>4/ Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргыг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчөөс томилсон гишүүд дотроос нэр дэвшүүлж, нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.</p>
20.	<p><b>Тавин нэгдүгээр зүйл.</b></p> <p>2. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.</p>	<p>Тавин нэгдүгээр зүйл</p> <p><u>2. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс бүх шатны шүүхийн шүүгчийг томилох шийдвэрээ Ерөнхийлөгчид хүргүүлнэ. Улсын дээд шүүхийн шүүгчийг томилох шийдвэрээ Ерөнхийлөгчид хүргүүлэхийн өмнө Улсын Их Хуралд танилцуулна. Ерөнхийлөгч Шүүхийн ерөнхий зөвлөлийн шийдвэрийг хүлээн авснаас хойш хорин нэг хоногийн дотор батламжилна. Үндсэн хуульд заасан шаардлага хангаагүй гэж үзвэл Ерөнхийлөгч шүүгчийг батламжлахаас татгалзаж, үндэслэлээ нийтэд мэдээлнэ.</u></p>
21.	<p><b>Тавин нэгдүгээр зүйл</b></p> <p>3. Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.</p>	<p>Тавин нэгдүгээр зүйл</p> <p><u>3. Хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр арван таваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын дөчин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр арван хоёр жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа томилно.</u></p> <p><u>Хууль зүйн дээд боловсролтой, хуульчийн мэргэжлээр таваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно. Давж заалдах шатны шүүхийн шүүгч нь тухайн шүүн таслах ажлын төрлөөр дагнан анхан шатны шүүхэд зургаагаас доошгүй жил шүүгчээр ажилласан байна.</u></p>



22.		<p><b>Тавин нэгдүгээр зүйл</b></p> <p>“5. Бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн дотроос нийт шүүгчдийн олонхийн саналаар гурван жилийн хугацаагаар сонгоно. Ерөнхий шүүгчийг тухайн шүүхэд нэг удаа улируулан сонгож болно.”</p>
23.	<p><b>Тавин долдугаар зүйл.</b></p> <p>1. Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.</p>	<p><b>Тавин долдугаар зүйл</b></p> <p><u>1. Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэл, хотод, аймаг нь сум, хот (орон нутгийн харьяалалтай)-д, сум нь багт, хот (орон нутгийн харьяалалтай) нь хороонд, нийслэл болон хот нь дүүрэгт, дүүрэг нь хороонд тус тус хуваагдана.”</u></p>
24.	<p><b>Тавин долдугаар зүйл</b></p> <p>2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.</p>	<p><b>Тавин долдугаар зүйл</b></p> <p>2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны <u>тосгоны</u> эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.</p>
25.	<p><b>Тавин наймдугаар зүйл.</b></p> <p>1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.</p>	<p><b>Тавин наймдугаар зүйл</b></p> <p><u>1. Аймаг, нийслэл, хот, сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлагатай, засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор бүхий, иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцох эрхтэй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж мөн. Баг, хороо бол засаг захиргааны анхан шатны нэгж мөн.”</u></p>
26.	<p><b>Тавин наймдугаар зүйл</b></p> <p>2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.</p>	<p><b>Тавин наймдугаар зүйл</b></p> <p>2. Аймаг, нийслэл, сум, <u>хот, сум, хот (орон нутгийн харьяалалтай)</u>, дүүргийн хилийн цэсийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.</p>

27.	<p><b>Тавин есдүгээр зүйл.</b></p> <p>2. Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн.</p>	<p><b><u>Тавин есдүгээр зүйл</u></b></p> <p><b><u>2. Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, хот, сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тухайн Хурлын чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн.</u></b></p>
28.	<p><b>Тавин есдүгээр зүйл</b></p> <p>3. Аймаг, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлыг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Эдгээр Хурлын болон сум, дүүргийн Хурлын төлөөлөгчдийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно.</p>	<p><b><u>Тавин есдүгээр зүйл</u></b></p> <p><b><u>3. Аймаг, нийслэл, хотын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн тоо, сонгох журмыг хуулиар тогтооно. Сум, дүүрэг, хот (орон нутгийн харьяалалтай)-ын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг тухайн нутаг дэвсгэрт оршин суугч иргэд сонгоно. Сум, дүүрэг, хот (орон нутгийн харьяалалтай)-ын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд гагцхүү иргэн өөрийн нэрийг дэвшүүлэн оролцоно.”</u></b></p>
29.		<p><b>Тавин есдүгээр зүйл</b></p> <p>“4. Монгол Улсын нутгийн өөрийн удирдлагын үндсэн нэгж нь сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурал мөн. Сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд татвар тогтоох, өмчөө захиран зарцуулах эрхтэй байна.</p>
30.		<p><b>Тавин есдүгээр зүйл</b></p> <p>5. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал нь тухайн нутаг дэвсгэрт хамаарах асуудлаар хуульд заасан болон сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн иргэдийн</p>

		Төлөөлөгчдийн Хурлаас олгосон бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргана.”
31.	<b>Жардугаар зүйл.</b>  1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ.	<b>Жардугаар зүйл</b>  1. Аймаг, нийслэл, сум, <u>хот, сум, хот (орон нутгийн харьяалалтай),</u> дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ.
32.	2. Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно.	<b>Жардугаар зүйл</b>  <u>2. Аймаг, нийслэл, хотын Засаг даргыг тухайн нутгийн Хуралд танилцуулснаар Ерөнхий сайд, баг, хорооны Засаг даргыг сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн Засаг дарга дөрвөн жилийн хугацаагаар тус тус томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлж, огцруулна.</u>
33.	<b>Жардугаар зүйл</b>  3. Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална.	<b>Жардугаар зүйл</b>  <u>3. Сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн Засаг даргыг тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн бүх нийтийн сонгуулиар дөрвөн жилийн хугацаагаар сонгож, аймаг, нийслэл, хотын Засаг дарга арван тав хоногийн дотор батламжилна. Сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн Засаг даргын сонгуульд иргэн хуульд заасны дагуу бие даан нэр дэвшинэ. Сонгуулийн журмыг хуулиар тогтооно.”</u>
34.		<b>Жардугаар зүйл</b>  “4. Хуульд заасан үндэслэлээр аймаг, нийслэл, хотын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нийт төлөөлөгчдийн олонхийн саналаар аймаг, нийслэл, хотын Засаг даргыг огцруулах саналыг Ерөнхий сайдад, баг, хорооны иргэдийн дөрөвний нэгээс доошгүй нь баг, хорооны Засаг даргыг огцруулах саналыг сум, хот (орон нутгийн харьяалалтай),

		<p>дүүргийн Засаг даргад өргөн мэдүүлсэн бол арван тав хоногийн дотор уг асуудлыг шийдвэрлэнэ.</p> <p>Засаг даргыг огцруулах шийдвэр гаргасан тохиолдолд нөхөн томилох асуудлыг арван тав хоногийн дотор энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмын дагуу шийдвэрлэнэ.</p>
35.		<p><b>Жардугаар зүйл</b></p> <p>5. Сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн Засаг даргыг хуульд заасан үндэслэлээр огцруулах саналыг аймаг, нийслэл, хотын Засаг дарга сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн Хуралд оруулсан бол арван тав хоногийн дотор уг асуудлаар Хурал шийдвэр гаргаж, хариу мэдэгдэнэ. Хурал сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн Засаг даргыг огцруулах шийдвэр гаргасан тохиолдолд бүрэн эрхийн үлдсэн хугацаанд ажиллах Засаг даргыг аймаг, нийслэл, хотын Засаг дарга томилно.”</p>
36.	<p><b>Жаран нэгдүгээр зүйл.</b></p> <p>2. Засаг дарга тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй.</p>	<p><b>Жаран нэгдүгээр зүйл</b></p> <p>2. Засаг дарга тухайн аймаг, нийслэл, <del>сум, дүүрэг, баг, жөрөөны</del> <u>хот, сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн</u> Хурлын шийдвэрт хориг тавих эрхтэй.</p>
37.	<p><b>Жаран нэгдүгээр зүйл</b></p> <p>4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар мөн. Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно.</p>	<p><b>Жаран нэгдүгээр зүйл</b></p> <p>4. Аймаг, нийслэл, <del>сум,</del> <u>хот, сум, хот (орон нутгийн харьяалалтай),</u> дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар мөн. Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг Засгийн газар нэг бүрчлэн буюу нэг маягаар тогтооно.</p>
38.	<p><b>Жаран хоёрдугаар зүйл.</b></p>	<p><b>Жаран хоёрдугаар зүйл</b></p>

	<p>1. Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.</p>	<p>1. Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, <del>сум, дүүрэг, баг, хорооны</del> <u>хот, сум, хот (орон нутгийн харьяалалтай), дүүргийн</u> нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.</p>
39.	<p><b>Жаран хоёрдугаар зүйл</b></p> <p>3. Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно.</p>	<p><b>Жаран хоёрдугаар зүйл</b></p> <p>3. Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн <u>нийслэл, хотын</u> Хурал, Засаг даргад шилжүүлж болно.</p>
40.	<p><b>Жаран гуравдугаар зүйл.</b></p> <p>1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурал эрх хэмжээнийхээ дотор тогтоол, Засаг дарга захирамж гаргана.</p>	<p><b>Жаран гуравдугаар зүйл</b></p> <p>1. Аймаг, нийслэл, <del>сум,</del> <u>хот, сум, хот /орон нутгийн харьяалалтай/,</u> дүүргийн Хурал эрх хэмжээнийхээ дотор тогтоол, Засаг дарга захирамж гаргана</p>
41.		<p><b>Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг</b></p> <p><b>“5/ улс төрийн намын үйл ажиллагаа Үндсэн хууль зөрчсөн эсэх.”</b></p>

Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын алба

---o0o---